

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн  
2026 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 01/83  
дугаар албан бичгийн хавсралт

2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СӨБ-н ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН  
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Үндэслэл

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны дунд жил бүр уламжлан болгон явуулдаг эрдэм шинжилгээний үндэсний хурлыг багш, удирдах ажилтны судалгаа шинжилгээ хийх чадварыг дэмжих, судалгаанд суурилсан сургалтын үйл ажиллагааг сайжруулах, сургалтын байгууллага, дүүрэг, орон нутаг, үндэсний түвшинд харилцан туршлага хуваалцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1967 оноос “Сурган хүмүүжүүлэх уншлага”, 2009 оноос үндэсний эрдэм шинжилгээний хурлын хэлбэрээр тасралтгүй зохион байгуулж ирлээ.

Сэдэв:

2026-2027 оны хичээлийн жилд “Өгөгдөл, хиймэл оюуныг багшлахуй, суралцахуйд үр дүнтэй ашиглах нь” сэдвээр зарлаж байна.

Зорилго

Өгөгдөл болон хиймэл оюуныг ёс зүйтэй, бүтээлчээр ашиглаж, багшлахуй, суралцахуйд гарсан ахиц өөрчлөлт, туршлага, арга зүйн шийдэл, үр дүнг хэлэлцэн, түгээн дэлгэрүүлэхэд чиглэнэ.

Хамрах хүрээ

Эрдэм шинжилгээний хуралд СӨБ-н хүүхдийн цэцэрлэг болон ЕБС, МБТБСБ-ын чиглэлээр аймаг бүрээс шалгарсан 42, нийслэлээс шалгарсан 18 илтгэл хэлэлцэгдэнэ.

Зохион байгуулалт нь дараах үе шаттай байна:

1. Анхан шатанд: Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн түвшинд;
  2. Дунд шатанд: Бүс, сум, дүүргийн түвшинд;
  3. Ахисан шатанд: Үндэсний түвшинд;
- Эрдэм шинжилгээний хурлыг үндэсний хэмжээнд 2027 оны 04 дүгээр сарын 08-09-ний өдөр танхимаар зохион байгуулна;
  - Эрдэм шинжилгээний хурлыг “СӨБ-ын багш, удирдах ажилтан” болон “ЕБ, МБТБСБ-ын багш удирдах ажилтан” гэсэн хоёр чиглэлээр зохион байгуулна.

Үндэсний түвшний хурлыг зохион байгуулахдаа аймаг, нийслэлийн боловсролын газартай хамтран ажиллах бөгөөд энэ хүрээнд дараах байдлаар ажиллана. Үүнд:

- Аймаг, нийслэлийн хэмжээнд шалгарсан илтгэлийг заасан хугацаанд илтгэлд тавих техник шаардлагын дагуу боловсруулж, албан бичгийн хамт ирүүлэх;
- Аймгийн боловсролын газрууд илтгэгчдийн томилолтын зардлыг шийдэж, хурал зохион байгуулагдах газар хүрэлцэн ирэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 2026-2027 оны хичээлийн жилийн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад хамтран ажиллах, харилцан туслалцах зэрэг болно.

## Үндэсний түвшинд шалгарсан илтгэлийг ирүүлэх

- Нийслэлийн хувьд бүх хүүхдийн цэцэрлэг, сургуулийг хамруулан зохион байгуулж, СӨБ-оос шалгарсан 9, ЕБ, МБТБСБ-аас шалгарсан 9 илтгэлийг ирүүлнэ;
- Орон нутгийн хувьд аймаг бүрээс СӨБ-оос шалгарсан 1, ЕБ, МБТБСБ-аас шалгарсан 1 илтгэлийг ирүүлнэ;
- Илтгэлд багийн гишүүн бүрийн үүрэг, оролцоог нэг бүрчлэн тусгасан байна. Багийн гишүүдийн тооны дээд хязгаар 8 байх
- Тухайлбал:
  - Төслийг удирдсан;
  - Арга зүй боловсруулсан;
  - Мэдээлэл цуглуулсан;
  - Судалгааны тайлан бичсэн гэх мэт
- Аймаг, нийслэлийн хэмжээнд шалгарсан СӨБ-ын илтгэлийн гол агуулга бүхий хураангуй (6 хүртэл нүүр)-г [tserendejid@mier.mn](mailto:tserendejid@mier.mn) хаягаар, дэлгэрэнгүйг (3 хувь) ЭША Д.Цэрэндэжид (Багшийн хөгжлийн ордон, 304 тоот, харилцах утас:80822098)-т 2027 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 19-ний өдрийн 17:00 цагаас өмнө аймаг, нийслэлийн боловсролын газрын албан бичгийн хамт ирүүлнэ;
- Аймаг, нийслэлийн хэмжээнд шалгарсан ЕБ, МБТБСБ-ын илтгэлийн гол агуулга бүхий хураангуй (6 хүртэл нүүр)-г [burenjargal@mier.mn](mailto:burenjargal@mier.mn) хаягаар, дэлгэрэнгүйг (3 хувь) ЭША Г.Бүрэнжаргал (Багшийн хөгжлийн ордон, 304 тоот, харилцах утас: 94008280)-д 2027 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 19-ний өдрийн 17:00 цагаас өмнө аймаг, нийслэлийн боловсролын газрын албан бичгийн хамт ирүүлнэ;
- Хугацаандаа ирүүлээгүй илтгэлийг хүлээн авах боломжгүй.

## Хурал зохион байгуулах хугацаа

- Хурал зохион байгуулах байр болон харилцаа холбоо, тоног төхөөрөмжийн бэлтгэл хангах 03 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл;
- Хурал зохион байгуулах хугацаа 04 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд байна.

Илтгэлийг дараах шалгуур, оноогоор үнэлнэ. Үүнд:

Онол, арга зүйн үндэслэл, шинэлэг үзэл санааг тусгасан байдал	24 оноо
Мэдээлэл, үр дүнг боловсруулсан байдал	28 оноо
Илтгэлийг бүтэцчилсэн байдал	8 оноо
Хэл найруулга, техникийн шаардлага хангасан байдал	12 оноо
Илтгэх чадвар	28 оноо

Эдгээр ерөнхий шалгуур, үзүүлэлтийг тухай бүр нарийвчлан дэд шалгуураар үнэлнэ. Орон нутаг, дүүргийн түвшинд дэд шалгуур, үзүүлэлтийг өөрсдийн онцлогт тулгуурлан боловсруулан, ашиглаж болно.

## Илтгэлд тавих техник шаардлага

1. Илтгэлийг Microsoft Word программ дээр А4 хэмжээгээр, дээр доороос 2 см, зүүн талаас 2.5 см, баруун талаас 1.5 см, үндсэн текст Arial 10 pt, мөр хоорондын зай 1.5, зураг, хүснэгт, график доторх текст Arial 9 pt байх.
2. Илтгэлийн зураг, хүснэгт, график дугаартай, нэртэй, эх сурвалжтай байх.
3. Зураг, график уншигдахуйц чанарын шаардлага хангасан байх.

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС